



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1063
танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох “Эх орон нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор “Эх орон нам”-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Эх орон нам”-ын мөрийн хөтөлбөр /.....8.....хуудас/-ийг хэвсэрч ав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРТИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichigt2024\0420 GNAG-3.Docx

0001030713

Эх орон намын УТЗ-ийн хурал
2024 оны 03 сарын 17-ны өдөр



УРИА: **ӨӨРТӨӨ ИТГЭЖ,
ӨӨРСДӨӨ ХИЙЦГЭЭ**

**УИХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

ЭХ ОРОН НАМ

Эх орон нам: *Улс, үндэсний аюулгүй байдал, иргэнийхээ эрхийг бүх түвшинд чандлан хамгаалж, уламжлал хийгээд, орчин цагийн соёл иргэншил, хууль, эрх зүйт төр, нийгмийн тогтолцоог бий болгохын төлөө ажиллана.*

Эх орон намд итгэл үзүүлснээр:

- Үндэсний эв нэгдлийг эрхэмлэж, хүний хөгжлийг дээдлэн ард түмнийхээ өөртөө итгэх итгэлийг сэргээнэ.
- Ард түмнээ уламжлал, шинжлэх ухаан технологийн дэвшилд тулгуурласан инновацлаг “Хөдөө аж ахуй – үйлдвэрлэл”-ийн харилцаа бүхий чинээлэг улс оронд ажиллаж амьдрах нөхцлөөр хангана.
- Төрийн тогтолцоог боловсронгуй болгож, авлига, хээл хахууль, албан тушаалын гэмт хэрэг, нам дамжсан бүлэглэлийн үйл ажиллагааг таслан зогсооно.
- Хүн амын өсөлтийг дэмжих тулгуур асуудлуудыг тодорхойлж, тогтолцоог боловсронгуй болгоно.

УЛС ОРНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монголчууд бид ардчилал зах зээл, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн нийгмийн тогтолцоог сонгож “Улс төрийн тусгаар тогнолоо” жинхэнэ утгаар нь олж аван, төр улсынхаа үйл хэргийг өөрсдөө шийдэх болсноор улс орон, ард иргэдийн маань ахуй амьдралд үлэмж өөрчлөлт, ахиц гарсан.

Хэдий ийм ч нийгмийн баялагийг шударгаар хувиарлах зарчим алдагдаж, нам дамнасан улс төр, эдийн засгийн бүлэглэл тэднийг тойрон хүрээлэгчид хууль, шударга ёсыг завхруулах, улс орноо ил далдаар тонон дээрэмдэх болсноор улс орны хөгжлийн хурдацыг сааруулж, ард түмний төрд итгэх итгэлийг алдагдуулж, иргэдийн олонхи нь ядуурал, нийгмийн тэгш бус харилцааны золиос болж байна.

Монгол орны байгалийн баялагийн асар их нөөц лиценз хэлбэрээр дотоодын дамчид, гадаадын компаниудын мэдэлд шилжиж, тэр хэрээр бид түүхий эдийн хавсрага төдий орон болсон нь улс орны эдийн засгийн тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд аюул учруулах бодит нөхцөл болоод байна.

Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямрал, давагдашгүй хүчин зүйлийн нөлөө хийгээд, засаглалын доройтол нь улс орны амьдралд нөлөөлж, үнийн өсөлт, инфляци хэрээс хэтэрч, ард түмний амьжиргааны түвшинг улам бүр доройтуулсаар байна.

Улс орон, ард иргэдийнхээ улс төр, эдийн засгийн эрх чөлөөг улам бүр баталгаажуулж, үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс төрийн хүлээх үүрэг хариуцлагыг өндөржүүлэн, улс орны хөгжилд саад болж буй "хонгилын тогтолцоо"-ноос нэн даруй салах зайлшгүй шаардлагатай байна.

Иймд Үндсэн хуулиа дээдлэн Монгол төрийг "шинэчлэх" хариуцлагатай сонголт хийхийг Эх орон нам уриалж байна.

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ЗОРИЛТ

Эх орон нам улс орноо "хөдөө аж ахуй-үйлдвэрлэл"-ийн харилцаа бүхий бүсчилсэн хөгжлийн бодлогоор хөгжүүлнэ.

1.1 ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

1.1.1 Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалыг "тунхаглал"-аас бодит бодлого болгож, эдийн засгийн бүс нутгуудийг орчин цагийн дэд бүтцээр бүрэн хангах нөхцлийг бүрдүүлнэ.

1.1.2 Хүний хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийн хөгжлийн бүсүүдэд экспортын чиг баримжаатай, импорт орлосон үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар бүс нутаг бүрийг эдийн засгийн хувьд бие даах нөхцлийг бүрдүүлнэ.

1.1.2 Бүс нутгийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлж, өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна. Улсын төсвийн зардлын бүтцийг оновчтой болгоно.

1.1.3 Бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан татварын бодлогод дараах өөрчлөлтийг оруулна. Үүнд:

- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, дотоодын зах зээлийг гадаадын чанаргүй бараа, бүтээгдэхүүнээс хамгаалах үйлдвэрлэлд орчин үеийн техник технологи нэвтрүүлэх сонирхлыг урамшуулах зорилгоор импортын барааны гаалийн татварыг ялгавартай тогтооно.
- Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татварын адил тэгш нөхцөлөөр хангана.
- Мал аж ахуйн түүхий эд, эрдэс баялаг боловсруулах үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжиж хөгжүүлнэ.
- Бүс нутгийн байршлаас хамааран цалин тэтгэвэр тэтгэмжийн сүлжээг ялгавартай тогтоох эрхзүйн орчныг бүрдүүлж, татварын бодлоготой уялдуулна.
- Ашигт малтмал, байгалийн баялаг ашигласны төлбөрийг улсын төсөвт, харин орон нутаг ажиллаж байгаа уурхай, үйлдвэрийн газрын орлогын татварыг тухайн аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх бодлого хэрэгжүүлнэ. Ашигт малтмалын төрөл, орд газрын тогтоц, ашиглалтын нөхцөлийг харгалзан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг ялгавартай тогтоох үзэл баримтлалыг боловсруулна.

1.1.4 Гадаад улс, олон улсын санхүүгийн байгууллагын зээл, тусламж, хөрөнгө оруулалтын хэмжээг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн оновчтой зохицуулах, улсын төсвийн орлогын баазыг нэмэгдүүлэх, замаар эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангана.

1.1.5 Ажилгүйдлийг бууруулж, цалин тэтгэврийг үнэ ханшийн өсөлт, улс орны эдийн засгийн чадамжтай уялдуулан шат дараатайгаар нэмэгдүүлэх бодлого баримтална.

1.1.6 Төрийн албаны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээг тооцохдоо бүсчилсэн байдлаар ялгавартай тогтооно.

1.2 АЖ ҮЙЛДВЭР, ДЭД БҮТЭЦ

Бүс нутаг бүрийг тэнцвэртэй хөгжүүлэх, улс орны эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх, эрчим хүчний болон түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг бий болгох бодлогыг тууштай баримтална.

1.2.1 Төмрийн хүдрийг түүхийгээр экспортлох явдлыг хязгаарлаж, гангийн үйлдвэрлэл хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгоно.

1.2.2 Эдийн засгийн хөгжлийн бүсүүдэд одоо байгаа эрчим хүчний эх үүсвэрүүдэд технологийн шинэчлэл хийж хүчин чадлыг нэмэгдүүлэх, байгаль орчинд нөлөөгүй сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг бий болгох бодлогыг тодорхой болгож, дэс дарааг тогтооно.

1.2.3 Бүх аймаг сумын төвүүд, бусад хот, суурин газар, суурьшлын бүсүүдэд хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөний зураг-төсөл боловсруулах ажлыг дэс дараатайгаар улсын төсвийн хүрээнд авч хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.2.4 Зам, гүүрийн байгууламжийн зураг төсөл, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг шинэ түвшинд гаргах, лаборатори байгуулах, аймаг бүрт өмчийн олон хэлбэрт суурилсан зам гүүрийн ажил эрхлэх байгууллагыг бий болгож, үйл ажиллагааг тогтмолжуулах, замын арчлалт үйлчилгээг гүйцэтгэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.2.5 Ашигт малтмалын нөөцийг ашиглахдаа байгаль орчны асуудлыг эн тэргүүнд тавьж зохистой хэлбэрийг сонгох ба ойн болон усны сан бүхий бүс нутгийн экологийн тэнцвэрийг хадгалах үүднээс зарим төрлийн ашигт малтмал ашиглахыг хязгаарлах, аялал жуулчлал, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

1.2.6 Стратегийн ач холбогдолтой орд газрыг ашиглах асуудлыг иргэний нийгмийн болон байгаль орчны чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, орон нутгийн иргэдийг оролцуулан ил тод шийдвэрлэж байна.

1.2.7 Геологи хайгуул, зураглалын ажил, инженер хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлэх хөшүүргийг бий болгоно.

1.2.8 Хүнсний аюулгүй байдал, түүний үйлдвэрлэл, нийлүүлэлтэд тавих хяналтыг боловсронгуй болгож, чанаргүй хүнсний болон бусад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний импортыг хязгаарлах, олон улсын чанар стандартын жишигт хүрсэн, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн, бусад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дотооддоо бий болгох хөрөнгө оруулалт, санхүү зээлийн бодлого боловсруулж хэрэгжүүлснээр бүх сум, суурин газруудад жижиг үйлдвэрлэл хөгжих нөхцөлийг хангана.


1.2.9 Импортыг орлох, экспортод шинээр гаргах бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэгж байгууллагуудыг бодлогоор дэмжинэ.

1.2.10 Барилгын материалын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгоор түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.3 МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН

Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үр ашгийг нэмэгдүүлж, аюулгүй эрүүл, экологийн цэвэр хүнс, бүтээгдэхүүнээр ард иргэдийг хангана.

- 1.3.1 Хүнсний эрүүл ахуй, био аюулгүй байдлын үндэсний лаборатори хяналтын тогтолцоог бий болгож, бүс нутгуудийн салбар байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангана.
- 1.3.2 Уламжлалт аргаар мал аж ахуй, газар тариалан эрхлэх асуудлыг эрчимжсэн аргатай хослуулан хөгжүүлэх асуудлыг төрийн бодлого болгон дэмжиж, нүүдлийн соёл иргэншил, ахуй, өв уламжлалыг хамгаалах, хойч үедээ өвлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3.3 Усан сан хөв далан байгуулах, уст цэгийг нэмэгдүүлэх ажлыг хөдөө аж ахуйн салбарын гол зорилтын нэг болгон тавьж, хөтөлбөр боловсруулж, стратеги хэрэгжүүлнэ.
- 1.3.4 Аймаг бүрд орон нутгийн өмчид суурилсан мал нядалгааны газар, мах, хүнсний ногооны нөөцийн агуулахын аж ахуй байгуулж, малчид тариаланчдыг эрсдэлээс хамгаална.
- 1.3.5 Бэлчээрийн даацад тохирсон ашиг шим сайтай мал аж ахуйг хөгжүүлэх сонирхлыг малчдад бий болгох чиглэлээр төрөөс бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.3.6 Монгол орны онцлогт тохирсон зоо, мал эмнэлгийн оновчтой бүтцийг бий болгон нутгийн шилмэл омгийн мал сонгон үржүүлж, сүү, мах, ноос, ноолуурын чиглэлийн үүлдрийг түлхүү өсгөн мал аж ахуйн бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанарыг нэмэгдүүлнэ.
- 1.3.7 Газар тариалангийн эргэлтийн талбай, га-гаас авах ургацын хэмжээг 2 дахин нэмэгдүүлж жилд дунджаар 550-600 мянган тонн үр тариа хураан авч дотоодын гурилын хэрэгцээг бүрэн хангана.
- 1.3.8 Манай оронд нутагшсан болон нутагших чадвартай сортын үрийн санг бий болгоно. Төмс, хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээг бүрэн хангана.
- 1.3.9 Тариалангийн зориулалттай газрыг Монгол улсын иргэдэд удаан хугацаагаар эзэмшүүлэх, усалгаатай тариаланг хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгоно.
- 1.3.10 Байгалийн хадлан бэлтгэх ажлыг нэмэгдүүлж, малын шимт тэжээл үйлдвэрлэлийн салбарыг шинээр бий болгохыг зорино.



1.4 БАЙГАЛЬ ОРЧИН, ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Байгалийн баялгийн нөөцийн менежментийн салбар хоорондын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

- 1.4.1 Байгалын баялгийн нөөцийг экологи-эдийн засгийн үнэлгээний үндсэн дээр ашиглаж, иргэдийн ажлын байр, орлогын нэмэлт эх үүсвэрийг бий болгоно.
- 1.4.2 Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, дэвшилтэт технологи нэвтрүүлэн доройтсон, бохирдсон орчны нөхөн сэргээлтийг иж бүрэн хийж, иргэдийн эрүүл амьдрах орчныг бүрдүүлнэ.
- 1.4.3 Газрыг ашиглах, эзэмших, өмчлөх харилцааг зах зээлийн эдийн засгийн нийтлэг жишигт нийцүүлэн газрын салбар дундын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, байгалийн бүх төрлийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

1.4.4 Нэн ховор, аж ахуйн чухал ач холбогдолтой амьтдын тархац нутгийг тусгай хамгаалалтад авч, байгалийн гамшиг, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.5 Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалж хөрсний эвдрэл, цөлжилт, хээрийн түймэр зэргээс урьдчилан сэргийлнэ. Байгалийн баялаг, ашигт малтмал олборлож байгаа аж ахуйн нэгжүүдээс "Байгалийн нөхөн сэргээлтийн сан" бүрдүүлнэ.

1.4.6 Ус, агаар, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

1.4.7 Аялал жуулчлалын үйлчилгээний чанар стандартыг дэлхийн төвшинд хүргэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.8 Аялал жуулчлал дахь улирлын нөлөөллийг арилгаж өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого баримтална. Аялал жуулчлалын салбарт шинэ бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого барина.

ХОЁР. НИЙГМИЙН ЗОРИЛТ

Ядуурлыг зогсоож, хүн амын дийлэнх хэсгийг чинээлэг дундаж давхаргын төвшинд хүргэхийг зорино.

2.1 ЭРҮҮЛ МЭНД

Монгол Улсын хөгжлийн гол эх сурвалж хийгээд туйлын зорилго нь хүний хөгжил мөн. Хүн ам мэдлэг боловсролтой, эрүүл энх, боломжийн орлоготой байх нь хүний хөгжлийг хангах чухал нөхцөл гэж үзэж байна.

2.1.1 Эмнэлгийн үйлчилгээ, чанарын түвшинг ахиулж, бүсийн оношлогооны төв, аймгүүдийн болон дүүргүүдийн нэгдсэн эмнэдэгүүдийг 3-р шатлалын эмнэлгийн түвшинд хүргэх бодлого боловсруулна. Үүнд:

- Эмнэлгийн барилга байгууламжуудыг орчин үеийн эмнэлэгийн шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авна.
- Эмнэлэгүүдийг орчин үеийн эмчилгээ оношлогооны тоног төхөөрөмжөөр хангах, шинэчлэх асуудлыг нэгдсэн бодлогоор зохион байгуулна.
- Нарийн мэргэжлийн эмч, эмнэлэгийн ажилтан бэлтгэх, гадаад дотоодод сургах, хэвийн төлөвийг тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.1.2 Иргэдийг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах тогтолцоог бий болгох, иргэд өөрсдөө эрүүл мэндийнхээ төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх цогц арга хэмжээ авна.

2.1.3 Эм, эмийн бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, мэдээллийн санг бий болгоно.

2.1.4 Хар тамхи, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх хориотой эм бэлдмэлийн хууль бус худалдаа хэрэглээг бүрэн таслан зогсоох, салбар хоорондын бүтцийг бий болгоно.

2.1.5 Архи, тамхи хэрэглэх болон бусад хорт зуршлын эсрэг өргөн хүрээтэй ажил зохион байгуулж, архи, тамхины үйлдвэрлэл, импортод онцгой хяналт тогтооно.

2.1.6 Төрөлтийг дэмжих эдийн засгийн бодлогыг төрөөс авч хэрэгжүүлнэ. Сум бүрт төрөхийн

өмнөх, дараах амралт, сувилгааны газрыг сэргээн тохижуулна. Эх нялхасын эндэгдлийг зогсоох зорилт тавина.

2.1.7 Орчин үеийн тоног төхөөрөмжтэй оношилгоо, эмчилгээний төвийг аймаг бүрт байгуулах, орон нутагт эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх, эх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.1.8 Эмч мэргэжилтнийг хөдөө орон нутагт тогтвор сууршилтай ажиллуулахыг төрийн бодлогоор дэмжинэ. Бүх хүнийг эрүүл мэндийн даатгалд хамруулах бодлого баримталж, даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.

2.1.9 Ардын уламжлалт анагаах ухааны үр нөлөөтэй аргуудыг орчин үеийн анагаах ухаантай зохистой хослуулан хөгжүүлэх бодлого баримталж, эмийн үйлдвэрлэлийг өргөжүүлнэ.

2.2 БОЛОВСРОЛ

2.2.1 Бүх шатны сургуульд түүх, уламжлал, үндэсний соёл, ёс заншлын мэдлэг, хүмүүжил олгох, суралцагсад эх оронч үзэл төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.2.2 Хүүхдэд бие, бялдар оюуны өв тэгш хүмүүжил олгох сургалтын хөтөлбөр сургуулийн материаллаг орчныг бүрдүүлэх, төрөлжсөн танхим-лаборатори, соёл урлаг, спортын иж бүрэн цогцолбортой байх хэтийн төлөвийг боловсруулна.

2.2.3 Хүүхдэд 7-15 насанд багш төвтэй сургалтаар, 16-18 насанд мэргэжлийн сургалтаар бүрэн дунд боловсрол заавал олгох тогтолцоонд бүрэн шилжиж, сургууль завсардлыг үгүй болгоно.

2.2.4 Багш бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх тогтолцоог сургууль, аймаг бүс нутаг, улсын хэмжээний гэсэн бүтэцтэй болгож тасралтгүй ажиллагааг нь хангана. Чанар муутай сургалтаас иргэдээ хамгаална.

2.2.6 Их дээд сургуулийг олон улсын жишигт нийцэхүйц сургалтын хөтөлбөр, багш мэргэжилтнээр бэхжүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлж аттестатчилалд хамруулахыг зорино.

2.2.7 Техникийн болон нарийн мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх бодлого баримтална.

2.2.8 Оюуны өндөр чадамжтай, гончавъяас билэгтэй оюутан сурагчдад төрөөс дэмжлэг үзүүлж сурах орчин нөхцөлөөр хангана.

2.2.9 Бүх шатны сургууль цэцэрлэгийн барилга, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, сургалтын орчинг сайжруулах хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлж, сургалтын тохилог орчин бүрдүүлнэ.

2.3 ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ

Шинжлэх ухааны нэгэнт бүрэлдсэн чадамжийг хадгалан өсгөн хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, эрдэм шинжилгээний ажилд их дээд сургууль, эрдэмтэн мэргэдийн оролцоог өргөжүүлэх эрх зүйн хөшүүрэг бий болгоно.

2.3.1 Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлүүдийг улс орны бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлал, бүтцийн бодлогод нийцүүлэн шинэчлэн тодорхойлж, суурь болон хавсрага судалгаанд зарцуулах хөрөнгийн зохистой харьцааг тогтооно.

2.3.2 Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдын үр бүтээлтэй ажиллах нөхцөл бололцоо, нийгмийн баталгааг хангаж, оюуны болон материаллаг бүтээмжийн үр дүнг дээшлүүлэх бодлого боловсруулж дэмжинэ.

2.3.3 Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, боловсролын уялдаа холбоог оновчтой болгож, шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлээр нарийн мэргэшсэн судлаачид бэлтгэх, залуу эрдэмтдийг дэмжих өнөөгийн бодлогыг боловсронгуй болгоно.

2.3.4 Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан бүрдүүлж төрийн хамгаалалтад авна.

2.4 СОЁЛ УРЛАГ, ШАШИН

Нүүдэлчний өвөрмөц нандин түүх, соёл, урлаг, уламжлалын өвийг хадгалан орчин цагийн ололтоор баяжуулан хөгжүүлэх зорилт тавина.

2.4.1 Сонгодог болон хүүхдэд зориулсан урлагийг төрөөс дэмжин хөгжүүлнэ. Ардын дуу хөгжим, тоглоом наадгай, урлаг болон уран дархны арга зэрэг соёлын өвийг хадгалан өвлүүлнэ.


2.4.2 Түүх соёлын зүйлийг сэргээн засварлах бүтцийг бий болгох, мэргэжилтэн бэлдэх тогтолцоог бүрдүүлэх замаар сүм хийд болон бусад түүх соёлын өв, байгууламжуудыг хуучин дэг жаягаар нь засварлах, хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.4.3 Түүх соёлын дурсгалт зүйлс, ардын урлаг, шинжлэх ухаан, мэдлэгийн үнэт өв, уламжлалт зан заншлыг үндэсний онцгой баялаг гэж үзэн төрийн хамгаалалтад байлгана.

2.4.4 Номын сан, музейн сан хөмрөгийг арвижуулан үйлчилгээний шинэ хэлбэр, хадгалалт хамгаалалтын шинэ технологийг үе шатгай нэвтрүүлнэ.

2.4.5 Уран бүтээлчдийн ховор, нандин, онцгой бүтээл туурвилыг төр худалдан авч холбогдох музей, галарейд хадгалж хамгаалах ажлыг дэмжинэ.

2.4.6 Уламжлалт шашин, зан үйлийн өнөөгийн байдлыг үнэлж, шашины байгууллагад тавих хяналтын тогтолцоог бий болгоно.



Төр захиргааны байгууллагуудын бүтэц, тогтолцоог боловсронгуй болгож, хүмүүнлэг иргэний эрх зүйт төрийн тогтолцоог төлөвшүүлнэ.

3.1 Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг боловсронгуй болгож, хууль, ёс зүйг дээдэлж бүх шатанд хариуцлагын тогтолцоог бий болгоно.

3.2 Үндэсний аюулгүй байдлыг хангах гол арга зам нь хараат бус хүчтэй эдийн засгийг бүрдүүлэх явдал гэж үзнэ.

3.3 Шүүх, хууль хяналтын байгууллагын тогтолцоо нь Засгийн газар болон хууль тогтоох байгууллагаас хараат бус ажиллах арга механизмыг бий болгоно. Хууль хяналтын байгууллагад шинэтгэл хийнэ.

3.4 Сонгуулийн пропорциональ системийг дэмжинэ.

3.5 Төр засгийн боловсон хүчнийг шилж сонгохдоо намын харъяаллыг бус боловсрол, мэдлэг, мэргэжлийн чадвар, ажил амьдралын дадлага туршлага, ёс зүйн хэм хэмжээг эн тэргүүнд чухалчлан үзнэ.

3.6 Бүх төрлийн лиценз, зөвшөөрөл олгодог журмыг хялбар болгон тоог цөөрүүлж шат


дамжлага, чирэгдлийг арилган иргэд, олон нийтийн хяналтыг хүчтэй болгоно.

3.7 Хөрш хоёр улстайгаа тогтоосон уламжлалт харилцааг хүндэтгэн үзэж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

3.8 Хоорондоо зөрчилтэй хууль, тогтоомжуудыг нэгтгэн цэгцэлж уялдаа холбоог хангана. Хуулийн хэрэгжилтэд тавих бүх шатны хяналтыг өндөржүүлнэ.

3.9 Ард түмнээ үнэн бодит мэдээллээр хангадаг нөлөөт хэвлэлийг дэмжиж, хариуцлагатай сэтгүүл зүйг төлөвшүүлнэ.

3.10 Нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг эрхэмлэнэ.



МОНГОЛ УЛС
МОНХӨД МАНДАН БАДРАГ